

## Өргөлтийн ажлын аюул эрсдэл

2023 оны 4-р сар



Зураг 1. Хлортой ISO танкийг өргөх үед кабель тасарсан

3-р сарын Веасон - нд Йорданы Акаба портод хлортой ISO танкийг ачих үедээ онгоцны тавцан руу унаган, 25 тонн хлорын хий гадагш алдсан ослыг оруулав. Энэ осол 13 хүний амь эрсдэж, 300 гаруй хүн эмнэлэгийн тусламж авсан байна. Энэ сэрэмжлүүлгийн цуврал нь хорт хийн аюулууд дээр илүү анхаарал хандуулсан ба ослын биет/бодит шалтгаан болох аюултай химийн бодисыг ачих, буулгах өргөлтийн ажлын муу зохион байгуулалт дээр голлон анхаарна. Албаны хүмүүсийн мэдэгдсэнээр танкны жин өргөх троссны даацаас гурав дахин их байсан.

Видео бичлэг дээр тросс тасарч, танк задарч байгааг харуулж байгаа ба дээрхи 1-р зураг дээр бичлэгээс дарж авсан 2 зургийг оруулсан [<https://youtu.be/0XYkMS6IMUs>]

Албаны хүмүүс мөн энэ төрлийн аюултай химийн бодистой харьцах үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагатай арга хэмжээг аваагүй ба тухайн үед тавцан дээр ачих, буулгах явцыг шалгах ур яадвартай ажилтан байгаагүйг мэдэгдсэн.

### Та үүнийг мэддэг үү ?

- Үйлдвэрийн тоног төхөөрөмж эсвэл химийн бодисыг зөөх аль ч өргөлтийн ажил нь аюултай ажил юм. Зарим улс орнууд ба компанид аливаа өргөлтийн ажлын өмнө заавал өргөлтийн төлөвлөгөө боловсруулж, зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Ийм өргөлтийн ба зөвшөөрөлд тусгасан зарим зүйлс нь :
  - Өргөхөд ашиглах тоног төхөөрөмжийг өргөх ачааны жинд тохирох эсэхийг үнэлсэн байх ёстой. Мөн нэрлэсэн хүчин чадлыг тэмдэглэсэн тодорхойлолттой байх.
  - Өргөлтийн татлагууд нь аюулгүй ашиглах үүднээс нэрлэсэн температурын хязгаартай байх.
  - Өргөлтийн тоног төхөөрөмжинд ашиглахын өмнөх үзлэг хийсэн байх ёстой.
  - Краны оператор болон оосорлогч нь өргөхөд ашиглах тоног төхөөрөмжийн үнэмлэхтэй байх ёстой.
- Краны оператор краны хөдөлгөөнийг хянана. Оосорлогч нь ачааг холбох, краны хөдөлгөөний үед краны операторт дохио өгөх, ачааг салгах ажил гүйцэтгэнэ. Өргөлтийн төлөвлөгөө нь цаг агаарын нөхцөлийг харгалзан үзэх шаардлагатай.
- Аюултай химийн бодис, төхөөрөмжийг ажиллаж буй тоног төхөөрөмжийн дээгүүр өргөх үед өргөлтийн төлөвлөгөөнд онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээг тусгасан байх шаардлагатай.

### Та юу хийж чадах вэ ?

- Ажилд оролцох бүх хүмүүс өргөлтийн төлөвлөгөө болон өөрийн гүйцэтгэх үүргээ мэдэж байгааг шалгах.
- Краны оператор болон оосорлогч нь радио холбоо ашиглаж байсан ч ижил гар дохио хэрэглэж байгааг баталгаажуулах. Өргөж буй ачааг буулгах хэсэгт үзлэг хийсэн, хангалттай зайтай, тухайн хэсгийг чөлөөлсөн байгааг нягтлах.
- Хэзээ ч бэлтгэлгүйгээр бүү хий. Хэрэв өргөлтийн төлөвлөгөөг бичсэний дагуу гүйцэтгэх боломжгүй бол ажлыг ЗОГСОО! Нөхцөлийг дахин хянан, зохих хүмүүсийг оролцуулан өргөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна. Үүнд анхны төлөвлөгөөг баталсан болон бусад хүмүүс байлцана.
- Өргөлтийн талбайгаас хүмүүсийг холдуул. Хэн ч ачааны доогуур гарах ёсгүй.
- Цаг агаарын нөхцөлийг ажигла. Салхи, хур тунадас нь өргөлтийн ажлыг улам аюултай болгодог. Өргөлтийн ажлыг хэзээ зогсоохоо мэддэг байх.

**Өргөлтийн журам нь өргөлтийн ажил эхлэхээс ӨМНӨ аюулгүйн бүх урьдчилсан арга хэмжээ авсан байгааг баталгаажуулах ёстой.**